

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын нэрийн өмнөөс гаргасан хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг иргэн, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд сайн дураар биелүүлээгүй тохиолдолд тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн байгууллага хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадан гүйцэтгэдэг. Иргэнд учирсан эд хөрөнгийн болон эдийн бус хохирлыг бүрэн нөхөн төлүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх нь гэмт этгээдийг олж илрүүлэн шийтгэхээс дутуугүй ач холбогдолтой юм.

2002 оноос хойших хугацаанд иргэний хэргийн талаархи шүүхийн шийдвэрийг үндэслэн олгосон гүйцэтгэх баримт бичиг дунджаар нийт гүйцэтгэх баримт бичгийн 70 гаруй хувийг эзэлж байгаа бөгөөд тэдгээрийн бодит гүйцэтгэл оноос он дамжин 50 орчим хувьтай байсаар байгаа нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан зорилтын хэрэгжилт хангалтгүй байгааг илтгэж байна. Түүнчлэн Эрүүгийн хуульд заасан “тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах”, “албадан ажил хийлгэх” зэрэг ялын хэрэгжилт хангалтгүй байгаа нь Эрүүгийн хуулийн 9.1-д заасан “Эрүүгийн хариуцлага гарцаагүй байх” зарчмыг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан дээр дурдсан зохицуулалт нь хохирогч бүр хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх, зөрчигдсөн эрхээ сэргээн эдлэх тэгш эрх, боломжтой байх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үр дүнтэй, хурдан шуурхай, бүрэн дүүрэн, зохих журмын дагуу гүйцэтгэх баталгаагаар хангасны үндсэн дээр хэрэгжих боломжтой юм.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.4.1-д: “Хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгож, иргэдэд чирэгдэлгүй, ялгаваргүй, тэгш, шударгаар үйлчлэх эрх зүйн орчинг цогцоор нь бүрдүүлнэ.” гэж, 5.4.10-т: “Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд бүрэн шилжүүлэх, цагдан хорих байрны нөхцөлийг хүний жам ёсны эрхэд нийцүүлэх, ял эдлүүлэх ажиллагаанд цахим болон телекамерын хяналтын системийг нэвтрүүлэх, ялтныг хөдөлмөрт бүрэн хамруулах, иргэний хэргийн талаархи шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн зарим ажиллагааг онлайн хэлбэрт шилжүүлэх замаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шинэтгэнэ.” гэж заасан. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 193 дугаар тогтоолоор “Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй болон хаалттай тогтолцоонд шилжүүлэх хөтөлбөр”, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталсан.

Дээр дурдсан зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд батлагдсан 2017 оны 7 сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд ял, шийтгэлийн төрөл, хэлбэрийг шинээр тодорхойлж, хорих ялыг нээлттэй, хаалттай хорих байгууллагад, өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад тус тус эдлүүлэх, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, шийтгэл оногдуулахаар тусгаж, ял, шийтгэл, албадлагын арга хэмжээний төрлийг шинээр тодорхойлсон нь дээр дурдсан ял, шийтгэл оногдуулсан шийдвэрийг гүйцэтгэх, хяналт тавих ажиллагааг шинээр журамлах шаардлагыг бий болгож байна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:

Хуулийн төслийг шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулах бөгөөд хуулийн төсөл нь 5 хэсэг, 28 бүлэгтэй. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараахь зарчмын шинжтэй зохицуулалтыг шинээр тусгасан.

I хэсэг: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны ерөнхий үндэслэл

1.Хуулийн зорилт, шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль тогтоомж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах үндэслэл, баримтлах зарчим, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тодорхойлолт, шийдвэр гүйцэтгэх болон тогтоол гүйцэтгэх ажиллагаанд тавих нийтлэг шаардлага, хориглох үйлдэл, эс үйлдэхүйг тодорхойлсон.

2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаан дахь шийдвэр гүйцэтгэгч болон тогтоол гүйцэтгэгчийн шийдвэрийн хэлбэр, тэдгээрийн агуулгыг тодорхойлно. Үүнээс гадна шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх буюу шүүхийн шийдвэр гарснаас хойш хуульд заасан тодорхой хугацаа өнгөрсөн тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахгүй байх хугацааг тодорхой зааж, тэжээн тэтгэхтэй холбогдсон болон төлбөр төлөгчид тодорхой хугацааны давтамжтай төлбөр төлөх болон бусад үүрэг хүлээлгэсэн шийдвэрийг үүрэг хүлээлгэсэн бүхий л хугацааны туршид албадан гүйцэтгэх боломжтой байхаар тусгана.

II хэсэг: Иргэний хэргийн талаархи шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн иргэний хэргийн талаархи шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай хоёрдугаар хэсэгт заасан зохицуулалтыг зарчмын хувьд хэвээр хадгалж, дараах зохицуулалтыг шинээр тусгалаа.

1.Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны харьяаллын талаархи зохицуулалтыг шинээр авч үзнэ. Үүнд шийдвэр гүйцэтгэгч өөрийн хариуцсан тойргоос бусад газарт аливаа ажиллагаа явуулах шаардлагатай тохиолдолд шийдвэр гүйцэтгэгчийн даалгавар хүргүүлэн гүйцэтгэх, цаг үеийн хэрэгцээ шаардлагаас үүдэн нэг төрлийн шийдвэрийг дагнан гүйцэтгэх чиг үүрэг бүхий нэгжээр шийдвэр гүйцэтгүүлэх, гүйцэтгэх шаардлага болон хамрах нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамааран шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шийдвэр гүйцэтгэгч нараас бүрдсэн хэсгээр гүйцэтгүүлэх, нэг төлбөр төлөгчид холбогдох хэд хэдэн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нэгтгэн гүйцэтгэх боломжийг бий болгосон.

2.Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг үүссэн шаардлага, нөхцөлөөс хамааран хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь түдгэлзүүлэх, дуусгавар болгох тухай зохицуулалтыг бий болгон шийдвэр гаргах эрх бүхий субъектийг тодорхойлж, түдгэлзүүлсэн тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч түдгэлзсэн үндэслэлийг арилсан эсэхэд тогтмол хяналт тавьж байх тухай зохицуулалтыг тусгасан.

3.Гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаах, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох үндэслэлийг тодорхойлохдоо тэжээн тэтгэхтэй

холбогдсон шийдвэрийг үүрэг хүлээлгэсэн бүхий л хугацаа хугацааны туршид гомдол гаргах, зөрчигдсэн эрхээ сэргээлгэх боломжтой байхаар тусгасан.

4.Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд хэрэгжүүлдэг бүхий л арга хэмжээг гүйцэтгэх баримт бичгийн гүйцэтгэлийг баталгаажуулах /хөрөнгө битүүмжлэх, барьцаалах, хураан авах, эд зүйлд үзлэг хийх, нэгжлэг хийх, үнэлгээ тогтоох гэх мэт/ албадлагын арга хэмжээг тодорхойлж, тэдгээрийг гүйцэтгэх үндэслэл, журмыг тогтоосон.

5.Гүйцэтгэх баримт бичгийн гүйцэтгэлийг баталгаажуулах зорилгоор шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг түдгэлзүүлэх, төлбөр төлөгч түүний эд хөрөнгийг эрэн сурвалжлах тухай зохицуулалтыг шинээр авч үзсэн.

6.Шүүхийн шийдвэр, шийдвэр гүйцэтгэх хуудаст төлбөр гаргуулах хөрөнгө, орлого, эрхийг тодорхой заагаагүйгээс шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн өмчлөх эрхэд өөрийн үзэмжээр халддаг зохицуулалтыг өөрчилж, гүйцэтгэх хуудаст төлбөр гаргуулах хөрөнгө, орлого, эрхийг тодорхой заадаг байхаар тусгаж, үүнтэй холбоотой холбогдох хуульд өөрчлөлт оруулсан.

7.Шүүхийн шийдвэрийн биелэлтийг бодитой хангахын тулд төлбөр төлөгчийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлж, үйл ажиллагаа явуулах боломжийг хязгаарлахад чиглэсэн зохицуулалтыг тусгасан.

8.Төлбөр төлөгчийн төлбөрт суутгахаар тогтсон хөрөнгийн төрөл, тэдгээрийн онцлогоос хамааран шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг явуулах, үнэлгээ тогтоох онцлог, тэдгээрийг албадан худалдан борлуулах ажиллагааны журмыг нарийвчлан тогтоосон.

9.Төлбөр төлөгчийн эрхийг хамгаалах, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр дүнтэй байдлыг хангах зорилгоор төлбөр төлөгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бүхий л шатанд төлбөрт суутган албадан худалдан борлуулахаар тогтсон хөрөнгийг өөрөө бие даан худалдан борлуулах эрхтэй байхаар тусгасан.

10.Төлбөр төлөгчийн хөрөнгийг албадан борлуулах ажиллагаа, албадан борлуулахаар тогтсон хөрөнгийг санал болгох анхны болон хоёр дахь дуудлага худалдааны үнийг тогтоох журмыг тусгасан. Тухайлбал, дуудлага худалдаа нь анхны үнэд хүрэх санал гараагүй, эсхүл нэг ч этгээд оролцоогүй үндэслэлээр хүчингүй болсон тохиолдолд хоёр дахь дуудлага худалдааны үед үнийг буулгах, харин дуудлага худалдаанд ялсан этгээд төлбөрийг хугацаанд нь шилжүүлээгүйн улмаас хүчингүйд тооцсон бол хоёр дахь дуудлага худалдааны үед үнийг бууруулахгүй байх тухай зохицуулалтыг төсөлд тусгасан

11.Худалдан борлогдоогүй хөрөнгийг төлбөр авагчид санал болгох үнийг шинээр тогтоож, хөрөнгийн анхлан тогтоосон үнийг 50 хувиар буюу хоёр дахь дуудлага худалдаанд санал болгосон доод үнэтэй дүйцүүлэн бууруулан тооцож төлбөрт суутган авах тухай зохицуулалт болон шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудын биедээ биедээ гаргасан ижил төрлийн харилцан шаардлагыг ихээс нь багыг нь суутгаж, төлбөр барагдуулсанд тооцох тухай зохицуулалтыг бий болгосон.

12.Төлбөр төлөгчийн цалин хөлс, бусад орлогоос суутгал хийх, тэжээн тэтгэхтэй холбогдсон төлбөрийг барагдуулах, төлбөр төлөгч-иргэн, төлбөр төлөгч-хуулийн этгээдэд холбогдуулан шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах журмыг тодорхойлсон.

III хэсэг: Захиргааны болон зөрчлийн хэргийн талаархи шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх

1.Захиргааны хэргийн талаархи шүүхийн шийдвэрийн төрлийг тодорхой болгож, хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг хэргийн оролцогч, эрх залгамжлагч заавал биелүүлэх үүргийг тусгасан.

2.Шийтгүүлсэн этгээд зөрчлийн хэргийн талаархи шүүхийн шийдвэрийг тогтоосон хугацаанд үл биелүүлсэн, эсхүл оргон зайлсан тохиолдолд шийтгэл оногдуулсан албан тушаалтан шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр шүүхэд хандах, шүүх гүйцэтгэх баримт бичиг үйлдэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлэх тухай зохицуулалтыг бий болгосон.

3.Шүүхээс шийдвэрийг албадан биелүүлэхээр гүйцэтгэх баримт бичиг олгохоос өмнө анх шийтгэл оногдуулсан байгууллага, албан тушаалтан өөрийн чиг үүрэг, эрх хэмжээний хүрээнд албадан гүйцэтгүүлэх ажиллагааг явуулах бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан шийдвэр гүйцэтгэгч, тогтоол гүйцэтгэгчийн эрхийг эдлэхгүй байхаар тусгасан.

4.Зөрчлийн тухай хуульд заасан торгох, эрх хасах шийтгэлийг гүйцэтгэх болон бусад албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх үндэслэл, журмыг тодорхой тусгасан.

IV хэсэгт: Эрүүгийн хэргийн талаархи шүүхийн шийдвэрийг биелүүлэх

1.2017 оны 7 сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх Эрүүгийн хуулийн 5.2 дугаар зүйлтэй нийцүүлэн торгох, зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх, эрх хасах ял оногдуулсан болон Эрүүгийн хуульд заасан бусад албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх ажиллагааны үндэслэл, журмыг тодорхойлж хорихоос өөр төрлийн ялыг хорих ялаар солих ажиллагааны журмыг тусгасан.

2.Эрүүгийн хуульд заасан хуулийн этгээдэд торгох, эрх хасах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх ажиллагааг иргэнд оногдуулсан торгох, эрх хасах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх ажиллагаатай ижил журмаар гүйцэтгэх, татан буулгах ял оногдуулсан шийтгэх тогтоолыг Иргэний хуульд заасан журмын дагуу шүүхээс томилсон комисс гүйцэтгэж, уг ажиллагаанд тогтоол гүйцэтгэгч хяналт тавьж байхаар заасан.

3.Албадлагын арга хэмжээ авагдсан хүнд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг биелүүлж байгаа эсэхэд тавих хяналт, хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээг гүйцэтгэх ажиллагааг шийдвэр гүйцэтгэгчид хариуцуулж, хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээг иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмын дагуу явуулахаар зохицуулсан.

4.Эрүүгийн хуульд нийцүүлэн нээлттэй, хаалттай хорих анги, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял эдлүүлэх харилцааг нарийвчлан тусгаж, нээлттэй, хаалттай хорих ангийн харуул хамгаалалтын зэрэглэл, ялтныг харуул хамгаалалтын ямар зэрэглэлд ял эдлүүлэх, зэрэглэл өөрчлөх асуудлыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага шийдвэрлэхээр заасан.

5.Хоригдлыг хөдөлмөрлүүлэх байнгын ажлын байр дутмаг байгаагаас ял эдэлж байгаа хоригдлын бусдад учруулсан хохирлыг барагдуулах боломж хязгаарлагдмал, хоригдлыг хорих ангийн дэглэмээс хамаарч хөдөлмөр эрхлэх боломжийг хязгаарласан зохицуулалтыг өөрчилж хөдөлмөр эрхлүүлэх, хохирол нөхөн төлүүлэх оновчтой тогтолцоог бүрдүүлсэн.

V хэсэгт: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, алба хаагчийн эрх зүйн байдал

1.“Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч” гэдэгт шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын албан хаагч, шийдвэр гүйцэтгэгч, тогтоол гүйцэтгэгч, хорих байгууллагын албан хаагчаас бүрдэхээр тусгаж, шийдвэр гүйцэтгэгч нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын цол, дүрэмт хувцастай байхаар зохицуулна.

2.Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн баталгааг улс төрийн, хууль зүйн, эдийн засгийн, нийгмийн болон бусад баталгаа болгон нарийвчлан зааж, биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх үндэслэл, журмыг тодорхой тусгана.

3.Шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын зохион байгуулалтын бүтцийг Шийдвэр гүйцэтгэх алба, Хорих ял эдлүүлэх алба, Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба гэх үндсэн нэгжтэй байхаар тодорхойлж, тэдгээрийн чиг үүргийг тодорхой тусган аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилтийг хангах зорилгоор “тогтоол гүйцэтгэгч” ажиллуулах зохицуулалтыг бий болгоно.

4.Тогтоол гүйцэтгэгчийг тойргийн журмаар ажиллуулж, торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, эрх хасах, хуулийн этгээдийг татан буулгах ялыг гүйцэтгэх, хорих ялаас хугацаанаас өмнө суллагдсан хүнд хяналт тавих, хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх үүргийг хариуцахаар заасан.

5.Нутаг дэвсгэр, хүн амын нягтаршил, шүүх, хууль сахиулах байгууллагын байршлыг харгалзан сум, дүүрэгт шүүхийн шийдвэр гүйцэтгэх нэгж байгуулах боломжтой байхаар тусгасан.

6.Хорих байгууллагын дотоод үйл ажиллагаа, үйлдвэрлэл, санхүүжилтийн оновчтой тогтолцоог бий болгох, ялтан ажиллуулах байнгын ажлын байрыг нэмэгдүүлэх, хорих байгууллага дахь үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор хорих ангийн хамгаалалтын бүсэд хувийн өмчийн хуулийн этгээд ажиллуулж болох, хорих ангийн болон хувийн өмчийн хуулийн этгээдийн үйлдвэрлэлээс олсон ашгийг байгууллагын үйл ажиллагааг дэмжих, ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулахаар тусгасан.